

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:** 1-5**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 6-15

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/ 7-9**2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/** 9-12**3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/** 12-15

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
3 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг;
Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Ж.Баярмаа, Б.Пүрэвдорж,
П.Сайнзориг, Б.Тулга.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын дарааллын нэгдүгээр асуудал болох “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж байгаа тухай мэдэгдэв. /10:20/

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар үг хэлэв.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, О.Номинчимэг, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг нар ажиллахаар тогтов.

Д.Цогтбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

52.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Д.Цогтбаатар: 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 9

Бүгд: 18

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын "дэмжсэн" санал техникийн саатлын улмаас "эсрэг" гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар. 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар. 3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ." гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Д.Цогтбаатар: 1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд "Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэц, түүний

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 31 минут үргэлжилж, ирвэл зохих 27 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр,

Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”

танхим

10 цаг 17 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Гишүүддээ хаврын чуулган эхэлсний 1 дүгээрт мэндийг хүргэе. Мөн түүнчлэн өнөөдөр цэргийн баяр тохиож байна. Цэргийн баярын мэндийг гишүүддээ хүргэе. Эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай бүгдэд нь би хүргэе гэж бодож байна ялгаварлахгүйгээр.

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан эхэлж байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны хурал эхэлснийг, нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Хуралдааны ирц Дамдины Цогтбаатар, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнайн Баярбаатар, Борхүүгийн Дэлгэрсайхан, Лхагвын Мөнхбаатар, Гонгорын Дамдинням, Одсүрэнгийн Номинчимэг, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ухнаагийн Отгонбаяр, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ирцтэйгээр 55.6 хувийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байгаа.

1 дүгээр асуудал, Байнгын хорооны төсөл. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 3 сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

2 дугаар асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”.

3 дугаар асуудал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

4 дэх асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай/ гэсэн ийм 4 асуудал хэлэлцэхээр байгаа.

Тэгээд энэ дээр би шууд 1 дүгээр асуудлыг эндээс хасъя гэсэн саналтай байгаа. Санал хураахгүйгээр шууд би хасчхаж болно гэж ойлгож байгаа. Яагаад гэхлээр энэ дээр нөгөө юу нь бэлэн биш байж байгаа юм. Их Хурлын даргын эхлээд заавал хэлэлцэх асуудлуудын энэ дугаар, жагсаалт гарах ёстой. Тэрийг гарч байж бид нар энийгээ батлах ёстой. Гэтэл Их Хурлын даргын тэр шийдвэр гараагүй байгаа юм байна лээ.

Тэгэхлээр эндээс энэ 1 дүгээр асуудлыг хасчихъя. Тэгээд 2 дугаар асуудлаасаа хэлэлцээд явъя.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал саналаа хэлнэ үү.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд алга. Тийм учраас хэлэлцэх асуудлыг баталлаа.

Тэгэхлээр Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах үндсэн дээр Улсын Их Хурал томилохоор зохицуулсан байдаг.

Энэхүү зохицуулалтын хүрээнд Хууль зүйн байнгын хороо холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн томилгооны сонсголыг явуулсан бөгөөд Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 2 гишүүнийг томилсон.

Нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүдээс гаргах явцад Монгол Улсын Их Хурлын 2021 оны 6 дугаар тогтоолоор баталсан сонгон шалгаруулах журмыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсантай холбогдуулан уг журмыг сайжруулж, хуульд нийцүүлэх чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлж байна.

Ингээд тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тогтоолын төслөө уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 2026 оны дугаар өдөр, дугаар Улаанбаатар хот, “Ажлын хэсэг байгуулах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам батлах тухай Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоолоор баталсан журмыг сайжруулж, хуульд нийцүүлэх

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Монгол Улсын Их Хурлын гишүүн энэ дээр чинь бид нар. Тэгье тэгвэл энэ дээр ингээд нэрсийг бол би нээлттэй оруулж ирж байгаа юм. Гишүүд маань тэгэхлээр өөрсдөө энэ дээр саналаа өгөөрэй. 1 дүгээр асуудал дээр бол тэгэхлээр 1 дүгээр хэсэг дээр нь бол энэ нэрс орно. Хэдүүлээ хэлэлцье.

2 дахь нь ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байгаа юм.

Тэгээд энэ дээр юу ажлын хэсэгт оръё гэсэн саналтай гишүүд байвал саналаа хэлээч энэ дээр. Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Өнөөдөр бас Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 105 жилийн ойн баярын мэндийг бас хүргэе.

Энэ ажлын хэсэг, энэ журам боловсруулах ажлын хэсгийг бол яаралтай байгуулах ёстой. Дэмжиж байна. Ганцхан энэ шүүгч бус Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн гэлтгүйгээр ер нь энэ Төрийн байгуулалтын байнгын хороон дээр жишээлбэл Үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах, Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах гээд энэ сонгон шалгаруулах, зохион байгуулдаг үйл явц маань өөрөө тодорхой журамгүй явж ирсэн байгаад байгаа юм.

Жишээлбэл, Үндэсний олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулахад дэд ажлын хэсэг байгуулаад дараа нь Байнгын хороо сонсгол зохион байгуулах хэмжээнд асуудлаа ярьж байгаа бол дэд ажлын хэсэг нь ажиллах журамгүй. Хуулиа бариад мэдээж ажиллах нь чухал. Тэгэхдээ эргээд нөгөө энэ дэд ажлын хэсэг сонгон шалгаруулалт хийх эрхтэй юү, эрхгүй юү гэдэг ийм маргаанууд үүсээд байгаа юм. Энэ дээр бол өнгөрсөн Номинчимэг гишүүн ахлаад явсан уу тээ? Тэн дээр бол яг ийм маргаан гарсан шүү дээ. Дэд ажлын хэсэг сонгон шалгаруулах эрхтэй юү, эрхгүй юү гэдэг. Иймэрхүү зүйлүүд байгаа учраас энэ журмыг бол яаралтай боловсруулж батлаад дараа дараагийн сонгон шалгаруулалтууд руугаа явахгүй бол энэ чинь хариуцлагатай албан тушаалтнуудыг тодорхой хугацаагаар томилж байгаа учраас бид нар энэ дээр бас хөнгөн хуумгай хандаж боломгүй байгаа юм. Тэгэхээр энэ журмыг бол яаралтай боловсруулж ажиллуулах нь зөв байх гэсэн бодолтой байна. Дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Тэгвэл би ийм байдлаар яачихъя. Ажлын хэсгийн ахлагч Баярбаатар гишүүн. Ажлын хэсгийн гишүүд Сайнзориг гишүүн, Ганбат гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Номинчимэг гишүүн гэсэн ийм 5-н гишүүнээс бүрдсэн ажлын хэсгийг тэгвэл байгууллаа.

Ингээд энэ дээр түрүүн би тогтоолын төслийг уншиж танилцуулсан байгаа. Одоо ингээд нэрсийг уншаад энэ гүйцэж байгаа юм.

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Ингээд тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдээрэй манайхан. Тэгвэл ингээд санал хураалт, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 52.9 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 1 дүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орёе.

10.28 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Энэ дээр Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир хийнэ. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд болсон бөгөөд хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Гангабаатар, Мөнхсайхан, Цолмон, Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Д.Отгонбаяр, С.Номынбаясгалан нар оролцсон. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн миний бие оролцсон.

Энэхүү хуралдаанаар дээр нэр дурдсан нэр бүхий Монгол Улсын иргэдээс Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн мэдээлэл буюу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг, Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэх хугацааг 3 хоногийн дараагаас эхлэн 10 хоногийн дотор буюу 7 хоног хэлэлцэн шийдвэрлэхээр тодорхой заасан байна.

Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн саналыг тавьснаас хойш 10 хоногийн дотор буюу 3 хоногийн дотор шийдвэрлэхээр заасан нь Улсын Их Хурлын тус асуудлыг хэлэлцэх хугацааг 4 хоногоор багасгасан байна.

Иймд тус хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгүүд, Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 43 дугаар зүйлийн 1 дэх, 44

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг холбогдох заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир миний бие Үндсэн хуулийн цэцэд хандан холбогдох тайлбар хүргүүлсэн.

Тус тайлбартаа ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж буй Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх хэсэгт зохих өөрчлөлт оруулан Үндсэн хуулийн холбогдох хэсэгтэй нийцүүлж өөрчлөхөөр тусгасан гэж тайлбарыг хүргүүлсэн.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаас дараах дүгнэлтийг Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гаргасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгтэй бас нийцээгүй байна.

Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсан.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Цогтбаатар: Ингээд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье.

Алга байна.

Тэгвэл Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Алга байна.

Тэгвэл одоо санал хураалтдаа бэлтгэнэ. 4 асуудлаар санал хураалт явуулахаар байгаа. Санал хураалтдаа бэлдье. Манайхан тэгвэл энийг дэмжээрэй Үндсэн хуулийн асуудал учраас. Бэлдье, манайхан дахиад бэлдчихье. Санал хураалтдаа бэлдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Сандагаа гишүүн. Тэгвэл горимын санал гаргаарай Сандагаа гишүүн. Тэгсэн тэгсэн бэлдсэн.

Ц.Сандаг-Очир: Санал хураалтад бэлтгэх үед нь орж амжаагүй учраас миний санал эсрэг гарчихлаа. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөд дахин санал хурааж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн би томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Тэр томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

3 дахь санал. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Эрдэнэболд гишүүнд микрофон өгье.

С.Эрдэнэболд: Сул дарчихсан юм байлгүй. Тэгэхдээ саяын дарсан санал төхөөрөмжид уншигдсангүй.

Гэхдээ би өөрийгөө яаж байгаа шүү буруу дарсан байна гэж. Тэгээд горимын саналаар дахиад санал хураалт явуулаад саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүн томьёоллыг уншаад танилцуулчихсан байгаа. Тэгээд түрүүн танилцуулсан томьёоллоор дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

4 дэх санал хураалт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн "... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор ... шийдвэрлэнэ." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд санал хураалт явж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах юм? Сандаг-Очир гишүүн танилцуулна.

3 дахь асуудалдаа оръё.

10.40 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Гишүүддээ өнөөдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Гангабаатар, Мөнхсайхан, Цолмон, Батрагчаа илтгэгч гишүүнээр оролцсон нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны Нарийн бичгийн даргаар Баяржаргалын Жаргаланг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийлээ.

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Өнгөрсөн онд бид Улсын Их Хурлын цэцэд хүсэлт гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн. Та бүхэн санаж байгаа бол Монгол Улсын Их Хурлыг Захиргааны анхан шатны шүүхэд дуудагдаад тэгээд Захиргааны анхан шатны шүүх Улсын Их Хуралд итгэмжилсэн төлөөлөгчөөр томилуулах тухай гаргасан шийдвэртэй холбогдуулаад ямар нэгэн баримт, мэдээллийг шүүхэд хүргүүлэх тухай тийм хүсэлт ирсэн.

Тэгээд Үндсэн хуулийн үзэл баримтлалаар бол Улсын Их Хурлыг ердийн шүүх дуудах эрхгүй. Үндсэн хуулийн цэц дээр л Улсын Их Хурлын шийдвэр хянагдах Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар, Үндсэн хуульд нийцэж буй эсэх асуудлаараа хянагдах ёстой. Тэгээд яагаад ч юм 1992 оны Үндсэн хуулийг Цэцийн тухай хуулийг бичихдээ Үндсэн хуулийн цэцэд шүүхэд харьяалан тогтоогдоогүй маргааныг шүүхийн харьяаллыг тогтоох тийм чиг үүрэг өгчихсөн юм байна лээ. Тэгээд сүүлд Дээд шүүхэд энэ чиг үүрэг бас олгогдсон. Тэгээд 2 чиг үүрэг нэг нь Үндсэн хуулийн шүүх дээр, нэг нь Дээд шүүх дээр ингээд давхацсан учраас энэтэй холбоотой хууль зүйн маргаан үүссэн. 2 дугаарт Үндсэн хуулийн маргаан үүссэн. Тэгээд тийм учраас Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаад Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжид байгаа энэ зүйл, заалтыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргаж ирэхийг хүссэн.

Бид бол өөрсдөө шууд хуулийг хүчингүй болгох боломжтой байсан боловч Цэцийн хууль тогтоомжид хүндэтгэлтэй хандаад Цэцээр өөрөөр шийдүүлэх зорилгоор энэ хүсэлтийг явуулсан. Үндсэн хуулийн цэц маргаан үүсгээд авч хэлэлцээд, дүгнэлт гаргаад, дүгнэлт дээрээ 2 зүйлээр дүгнэлт гаргасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн хуульд байгаа уг зохицуулалт Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг талаас бол дүгнэлт гаргасан. Гэхдээ иргэний үндсэн эрхийг хянахад энэ нь өөрөө саад болохгүй гэдэг утга агуулга бүхий бас зөвлөмж хэлсэн. Бас нэг зөвлөмж нь юу хэлсэн бэ гэхээр Дээд шүүхэд олгогдсон эрхийг зохицуулж байгаа хэм хэмжээний бичилт, Үндсэн хуулийн цэцэд байгаа энэ их хэмжээний билчэлт 2 чинь хоорондоо бас жоохон зөрүүтэй байгаа шүү. Энэ зөрүүг хооронд нь нийцүүлээд илүү боловсронгуй болгох чиглэлээр бас хууль тогтоох байгууллага цаашид анхаарч ажиллаарай гэдэг бас тийм зөвлөмж өгсөн.

Тийм учраас бид бол Дээд шүүхэд Шүүхийн тухай хууль дээр байгаа уг зүйл, заалтыг Үндсэн хуулийн цэцийн одоо хүчингүй болж байгаа энэ зүйл, заалттай харьцуулах байдлаар нэг дүгнэлт гаргаад эндээсээ бас аль нь илүү иргэний эрхийг хангаж байна, хууль тогтоомжийнхоо хувьд илүү зохистой байна гэдэг талаар бол нэг шийдэл Хууль зүйн байнгын хороонд бол хийх үүрэг бас үүсэх ёстой байх.

2-т нь Үндсэн хуулийн цэцийн хурал дээр дахин дахин яригдсан нэг зүйл нь бол ер нь Үндсэн хууль дээр байгаа үг, үсэг болон Үндсэн хуулийн цаашдын хөгжлийг бодоод Үндсэн хуулийн цэц иргэний үндсэн эрхийг хянахтай холбоотой зохицуулалтыг Улсын Их Хурал цаашид анхаарч шийдвэрлэвэл энэ зохицуулалтын Үндсэн хуулийн шүүхэд хандаад шударгаар шүүлгэх эрхээ хангуулж чадахгүй байгаа иргэдийн шүүхэд хандах эрхийг баталгаажуулах тэр агуулга бас илүү зохистой болох юм байна шүү гэдгийг бас дахин дахин тэр хэлэлцүүлгийн явцад яригдсан.

Тийм учраас Улсын Их Хурал энэ жил юм уу ирэх жил юм уу ямар нэгэн байдлаар Үндсэн хуулийн цэцтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

болох чиглэлээр жоохон хурдтай ажиллаад Монгол Улсад иргэний үндсэн эрхийн хамгааллыг Үндсэн хуулийн шүүх хянадаг байдлаар бий болгох нь бол энэ цаг үеийн бараг хууль тогтоогчид үүрэг байна гэдэг яриа бол их гарсан гэдгийг би энд дурдахыг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Тэгвэл энэ итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү.

Алга байна.

Тэгвэл 2 санал хураалттай байгаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан тэгвэл үг хэлэх дууслаа. Ингээд гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтаа эхэлье. Бүгдээрээ бэлэн үү?

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин гишүүн өөрөө танилцуулчих уу? Тэгвэл ингээд Их хурлын гишүүн Тэмүүжин танилцуулна нэгдсэн чуулганд.

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

10.48 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР